



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/252-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="mailto:www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a> Сүхбаатар сум 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040      Цахим хаяг: <a href="mailto:enkhtuyach@audit.gov.mn">enkhtuyach@audit.gov.mn</a> Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036      Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a> Аудитор: Ч.Цэрэннадмид Утас: 95112689      Цахим хаяг: <a href="mailto:ts.nadiiii@yahoo.com">ts.nadiiii@yahoo.com</a>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	10
3.Аудитын тайлан.....	13
3.1. Ерөнхий зүйл.....	13
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	13
3.3 Санхүүгийн тайлангийн үзэл баримтлал.....	14
3.4. Материаллаг байдал.....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал.....	177
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4.1 Залруулсан алдаа.....	18
4.2 Албан шаардлага, Зөвлөмж.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	20

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
МСҮТ	Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХНХС	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд
ХНХЯ	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМТ	Эрүүл мэндийн төв



## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.24 № 100 2022/252-НА-СТА-ТШЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ШААМАР СУМЫН  
МЭРГЭЖИЛ СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН  
ТӨВИЙН ЗАХИРАЛ Б.ХИШИГЖАРГАЛ ТАНАА

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>52,354,574.29</b>	<b>73,721,175.03</b>
<b>31</b>	<b>Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө</b>	-	<b>10,962.00</b>
<b>311</b>	<b>Кассанд байгаа</b>	-	
<b>312</b>	<b>Банкинд байгаа</b>		10,962.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	<b>13,988,314.44</b>
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага		
<b>335</b>	Бусад авлага	-	13,906,800.00
	Хувь хүнээс авах	-	81,514.44
3351	Байгууллагаас авах авлага		
	Найдваргүй авлагын хасагдуулга		
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>52,354,574.29</b>	<b>59,721,898.59</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>945,000.00</b>	-
35110	Тусгай зориулалттай материал		
35130	Эм боох материал	945,000.00	
35300	Бэлэн бүтээгдэхүүн		
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>48,604,574.29</b>	<b>56,826,898.59</b>
35410	Бичиг хэргийн материал		
35420	Аж ахуйн материал	33,152,082.00	36,648,760.00
35430	Сэлбэг хэрэгсэл	705,958.00	705,958.00
35440	Түлш шатах тослох материал	792,000.00	492,000.00
35450	Барилгын засварын материал	3,449,000.00	8,748,310.00
35460	Хүнсний материал	2,586,298.00	2,312,634.30
35470	Бусад хангамжийн материал	7,919,236.29	7,919,236.29
<b>356</b>	<b>Мал амьтад</b>	<b>2,805,000.00</b>	<b>2,895,000.00</b>
36	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>		
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,458,127,153.66</b>	<b>3,270,148,803.73</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>3,458,127,153.66</b>	<b>3,270,148,803.73</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгийн дүн</b>	<b>3,290,549,153.66</b>	<b>3,102,570,803.73</b>
39201	Барилга байгууламж	3,624,133,570.00	3,624,133,570.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(396,770,193.75)	(587,442,882.39)
39217	Тээврийн хэрэгсэл	274,150,051.20	287,714,051.20
39204	Хуримтлагдсан элэгдэл	(263,100,533.72)	(267,834,631.52)
39205	Машин тоног төхөөрөмж	210,648,716.00	220,353,999.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	(178,688,267.71)	(191,694,561.28)
39207	Тавилга, эд хогшил	34,958,720.00	34,958,720.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(23,651,042.36)	(26,485,596.08)
39217	Ном	8,868,134.00	8,868,134.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгийн дүн</b>	<b>167,578,000.00</b>	<b>167,578,000.00</b>
39301	Программ хангамж	16,805,000.00	16,805,000.00
39302	Хасагдуулга	(16,805,000.00)	(16,805,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	167,578,000.00	167,578,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,510,481,727.95</b>	<b>3,343,869,978.76</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,510,481,727.95</b>	<b>3,343,869,978.76</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>3,510,481,727.95</b>	<b>3,343,869,978.76</b>
511	Засгийн газрын оруулсан капитал	1,111,180,818.68	1,111,180,818.68
51101	Өмч: -төрийн	1,111,180,818.68	1,111,180,818.68
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>(1,713,005,972.13)</b>	<b>(1,879,617,721.32)</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,713,005,972.13)	(1,713,005,972.13)
51220	Тайлант үеийн үр дүн		(166,611,749.19)
51300	Дахин үнэлгээний зөрүү	4,112,306,881.40	4,112,306,881.40
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,510,481,727.95</b>	<b>3,343,869,978.76</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>1,156,138,200.00</b>	<b>1,189,912,205.80</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>11,314,000.00</b>	<b>18,621,483.80</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>11,314,000.00</b>	<b>18,621,483.80</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,314,000.00	18,321,483.80
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,600,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,850,000.00	7,016,200.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	2,254,000.00	9,705,283.80
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	210,000.00	300,000.00
13	<b>ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,144,824,200.00</b>	<b>1,171,290,722.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,144,824,200.00</b>	<b>1,164,629,900.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,144,824,200.00	1,164,629,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүдгээс санхүүжих		
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>-</b>	<b>6,660,822.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хувиарласан хөрөнгө		6,660,822.00
2	<b>Үйл ажиллагааны зардал</b>	<b>1,384,102,910.23</b>	<b>1,356,523,954.99</b>
21	<b>Урсгал зардал</b>	<b>1,384,102,910.23</b>	<b>1,356,523,954.99</b>
210	<b>Бараа, үйлчилгээний зардал</b>	<b>1,286,545,665.09</b>	<b>1,262,871,083.99</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал</b>	<b>578,331,988.18</b>	<b>593,968,660.99</b>
210101	Үндсэн цалин	372,273,108.00	353,352,772.34
210102	Нэмэгдэл цалин	144,451,131.20	177,476,499.83
210103	Унаа хоолны хөнгөлөлт	25,734,785.98	30,343,583.02
210104	Урамшуулал	35,872,963.00	32,795,805.80
2102	<b>Нийгмийн даатгалын шимтгэл</b>	<b>72,339,578.86</b>	<b>73,510,594.03</b>
210201	Тэтгэврийн даатгалын	49,803,923.99	50,334,208.92
210202	тэтгэмжийн даатгалын	5,851,148.05	5,917,689.79
210203	ҮОМШӨ-ий даатгалын	4,627,153.01	5,928,312.43
210204	Ажилгүйдлийн даатгалын	1,095,893.87	1,013,985.01
210205	ЭМ-ийн даатгалын	10,961,459.94	10,316,397.88
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>338,150,056.00</b>	<b>330,239,659.54</b>
210301	Гэрэл цахилгааны зардал	19,105,106.00	18,476,459.54
210302	Түлш, халаалтын зардал	316,044,950.00	309,063,200.00
210303	Цэвэр бохир усны зардал	3,000,000.00	2,700,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>21,767,545.00</b>	<b>19,187,590.00</b>
210401	Бичиг хэргийн зардал	494,100.00	2,029,000.00
210404	Тээвэр шатахуун	5,975,650.00	5,468,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн зардал	3,368,300.00	2,690,740.00

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210404	Ном, хэвлэл		33,300.00
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	1,575,000.00	1,697,800.00
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардал	9,769,495.00	7,058,750.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	585,000.00	210,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>16,585,791.00</b>	<b>14,114,773.70</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	2,196,750.00	984,200.00
210502	Хоол, хүнс	14,342,041.00	12,288,373.70
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	47,000.00	842,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>13,591,950.00</b>	<b>5,340,100.00</b>
210601	Багаж техник, хэрэгсэл	156,560.00	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	211,550.00	8,600.00
210604	Урсгал засварын зардал	13,223,840.00	5,331,500.00
<b>2107</b>	<b>Томилолтын зардал</b>	<b>1,055,100.00</b>	<b>-</b>
210702	Дотоодын томилолт	1,055,100.00	
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс</b>	<b>2,906,228.00</b>	<b>3,978,772.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр		950,000.00
210802	Аудит баталгаажуулалтын зардал	1,500,000.00	1,440,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	366,750.00	520,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.00	290,838.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	378,000.00	264,000.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	361,478.00	488,922.00
210807	Газрын төлбөр		24,212.00
<b>2109</b>	<b>Бараа, үйлчилгээний бусад зардал</b>	<b>241,817,428.05</b>	<b>222,530,933.73</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	12,577,900.00	11,283,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	229,239,528.05	211,247,633.73
<b>213</b>	<b>Урсгал шилжүүлэг</b>	<b>97,557,245.14</b>	<b>93,652,871.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>45,982,500.00</b>	<b>88,648,800.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,977,400.00	52,656,200.00
213208	Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	28,405,100.00	34,712,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	1,600,000.00	1,280,600.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>5,004,071.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		5,004,071.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>51,574,745.14</b>	<b>-</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	51,574,745.14	
<b>3</b>	<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>(227,964,710.23)</b>	<b>(166,611,749.19)</b>
<b>145</b>	<b>Үйл ажиллагааны бус орлогын дүн</b>		
<b>225</b>	<b>Үйл ажиллагааны бус зардлын дүн</b>		
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>-</b>	<b>-</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		
<b>4</b>	<b>Үйл ажиллагааны бус үр дүн</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>(227,964,710.23)</b>	<b>(166,611,749.19)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>1,153,674,200.00</b>	<b>1,180,656,922.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>8,850,000.00</b>	<b>9,366,200.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>8,850,000.00</b>	<b>9,366,200.00</b>
<b>120004</b>	<b>Төсөвт байгууллагын өөрийн орлого</b>	<b>8,850,000.00</b>	<b>9,366,200.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		2,150,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,850,000.00	7,216,200.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,144,824,200.00</b>	<b>1,171,290,722.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,144,824,200.00</b>	<b>1,164,629,900.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,144,824,200.00	1,164,629,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>-</b>	<b>6,660,822.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		6,660,822.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,153,674,200.00</b>	<b>1,179,895,960.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,153,674,200.00</b>	<b>1,179,895,960.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,056,116,954.86</b>	<b>1,086,243,089.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал</b>	<b>578,331,988.00</b>	<b>589,627,467.24</b>
210101	Үндсэн цалин	370,402,294.00	348,879,792.59
210102	Нэмэгдэл	146,321,941.02	177,608,285.83
210103	Унаа хоолны хөнгөлөлт	25,734,789.98	30,343,583.02
210104	Урамшуулал	35,872,963.00	32,795,805.80
<b>2102</b>	<b>Ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>72,339,578.86</b>	<b>77,933,302.22</b>
210201	Тэтгэврийн даатгалын	49,803,923.99	54,756,917.11
210202	Тэтгэмжийн даатгалын	5,851,148.05	5,917,689.79
210203	ҮОМШӨ-ий даатгалын	4,627,153.01	4,756,123.43
210204	Ажилгүйдлийн даатгалын	1,095,893.87	1,128,781.01
210205	Эрүүл мэндийн даатгалын	10,961,459.94	11,373,790.88
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>338,150,056.00</b>	<b>344,146,459.54</b>
210301	Гэрэл цахилгааны зардал	19,105,106.00	18,476,459.54
210302	Түлш, халаалтын зардал	316,044,950.00	322,970,000.00
210303	Цэвэр бохир усны зардал	3,000,000.00	2,700,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материал</b>	<b>23,065,345.00</b>	<b>22,873,400.00</b>
210401	Бичиг хэргийн зардал	2,182,849.00	4,473,500.00
210404	Тээвэр шатахуун	6,740,000.00	5,168,000.00
210403	Шуудан холбооны зардал, мэдээлэл тех-гийн үйлчилгээ	3,368,300.00	2,690,740.00
210404	Ном		33,300.00
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	4,151,500.00	4,235,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,622,696.00	6,272,260.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>15,116,337.00</b>	<b>12,936,110.00</b>
210501	Эм	2,859,000.00	79,200.00
210502	Хоол, хүнс	11,204,637.00	12,014,710.00
210503	Нормын хувцас	1,052,700.00	842,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил урсгал засвар</b>	<b>11,935,000.00</b>	<b>23,282,200.00</b>
210601	Багаж техник хэрэгсэл		
210602	Тавилга		

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	1,991,000.00	
210604	Урсгал засвар	9,944,000.00	23,282,200.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,055,100.00</b>	<b>-</b>
210702	Дотоодын томилолт	1,055,100.00	
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,194,150.00</b>	<b>3,969,850.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		950,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	1,440,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	366,750.00	520,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.00	290,838.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	378,000.00	264,000.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	649,400.00	480,000.00
210807	Газрын төлбөр		24,212.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>12,929,400.00</b>	<b>11,474,300.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	12,929,400.00	11,474,300.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>97,557,245.14</b>	<b>93,652,871.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>45,982,500.00</b>	<b>88,648,800.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,977,400.00	52,656,200.00
213208	Хөдөө орон нутагт тогтвортой ажилласан а/хаагчдад дэмжлэг	28,405,100.00	34,712,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	1,600,000.00	1,280,600.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэлт</b>	<b>51,574,745.14</b>	<b>5,004,071.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	51,574,745.14	5,004,071.00
<b>3</b>	<b>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>-</b>	<b>760,962.00</b>
<b>8</b>	<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>-</b>	<b>760,962.00</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		10,962.00

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны үр дүн
А	1	2	3	4
<b>2019 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл</b>	943,602,818.68	4,112,306,881.40	-	5,055,909,700.08
НББ-ийн бодлогын өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	943,602,818.68	4,112,306,881.40	-	5,055,909,700.08
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн	167,578,000.00		(1,713,005,972.13)	(1,545,427,972.13)

<b>2020 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл</b>	1,111,180,818.68	4,112,306,881.40	(1,713,005,972.13)	3,510,481,727.95
Тайлант үеийн үр дүн			(166,611,749.19)	(166,611,749.19)
<b>2021 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл</b>	1,111,180,818.68	4,112,306,881.40	(1,879,617,721.32)	3,343,869,978.76

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,177,729,600.00	1,168,231,067.00	9,498,533.00	99.3
21	Урсгал зардлын дүн	1,177,729,600.00	1,168,231,067.00	9,498,533.00	99.3
210	Бараа үйлчилгээний зардал	1,089,080,800.00	1,079,582,267.00	9,498,533.00	99.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	585,203,400.00	583,706,736.24	1,496,663.76	99.7
210101	Үндсэн цалин	388,278,000.00	348,879,792.59	39,398,207.41	89.9
210102	Нэмэгдэл	143,414,200.00	171,687,554.83	(28,273,354.83)	119.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,000,000.00	30,343,583.02	(3,343,583.02)	112.4
210104	Урамшуулал	26,511,200.00	32,795,805.80	(6,284,605.80)	123.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	79,032,900.00	77,193,211.22	1,839,688.78	97.7
210201	Тэтгэврийн даатгал	55,615,700.00	54,016,826.11	1,598,873.89	97.1
210202	Тэтгэмжийн даатгал	5,854,300.00	5,917,689.79	(63,389.79)	101.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,683,400.00	4,756,123.43	(72,723.43)	101.6
210204	Ажилгүйдлийн даатгал	1,170,900.00	1,128,781.01	42,118.99	96.4
210205	ЭМД-ын хураамж	11,708,600.00	11,373,790.88	334,809.12	97.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	348,562,000.00	344,146,459.54	4,415,540.46	98.7
210301	Гэрэл цахилгааны зардал	22,992,000.00	18,476,459.54	4,515,540.46	80.4
210302	Түлш, халаалтын зардал	322,970,000.00	322,970,000.00	-	100.0
210303	Цэвэр бохир усны зардал	2,600,000.00	2,700,000.00	(100,000.00)	103.8
2104	Хангамж, бараа материалын зардал	22,873,100.00	22,873,400.00	(300.00)	100.0
210401	Бичиг хэрэг	1,822,200.00	4,473,500.00	(2,651,300.00)	245.5
210402	Тээвэр шатахуун	4,285,900.00	5,168,000.00	(882,100.00)	120.6
210403	Шуудан холбоо	3,560,300.00	2,690,740.00	869,560.00	75.6
210404	Ном	33,000.00	33,300.00	(300.00)	100.9
210405	Хог хаягдал	10,849,800.00	4,235,600.00	6,614,200.00	39.0

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210406	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	2,321,900.00	6,272,260.00	(3,950,360.00)	270.1
2105	Нормативт зардал	13,503,200.00	12,936,110.00	567,090.00	95.8
210501	Эм	79,200.00	79,200.00	-	100.0
210502	Хоол хүнс	12,581,800.00	12,014,710.00	567,090.00	95.5
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	842,200.00	842,200.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,282,200.00	23,282,200.00	-	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл			-	
210604	Урсгал засвар	23,282,200.00	23,282,200.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	844,100.00		844,100.00	0.0
210702	Дотоод томилолт	844,100.00		844,100.00	0.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	4,287,100.00	3,969,850.00	317,250.00	92.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	950,000.00	950,000.00	-	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	1,440,000.00	60,000.00	96.0
210803	Даатгалын үйлчилгээ	520,800.00	520,800.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	301,800.00	290,838.00	10,962.00	96.4
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	312,000.00	264,000.00	48,000.00	84.6
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	519,500.00	480,000.00	39,500.00	92.4
210807	Газрын төлбөр	183,000.00	24,212.00	158,788.00	13.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,492,800.00	11,474,300.00	18,500.00	99.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,492,800.00	11,474,300.00	18,500.00	99.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	88,648,800.00	88,648,800.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	88,648,800.00	88,648,800.00	-	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	52,656,200.00	52,656,200.00	-	100.0
213208	Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж	34,712,000.00	34,712,000.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	1,280,600.00	1,280,600.00	-	100.0
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,177,729,900.00	1,173,996,100.00	3,733,800.00	99.7
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,164,629,900.00	1,164,629,900.00	-	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,164,629,900.00	1,164,629,900.00	-	100.0
	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	13,100,000.00	9,366,200.00	3,733,800.00	71.5
	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,500,000.00	2,150,000.00	5,350,000.00	28.7
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,600,000.00	7,216,200.00	(1,616,200.00)	128.9

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	Мөнгөн хөрөнгийн 2020/01/01-12/31-ний үлдэгдэл	(1,177,729,600.00)	(1,168,231,067.00)	(9,498,533.00)	99.2
	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл			-	
	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		10,962.00	(10,962.00)	
001	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	93.00	93.00	-	100.0
002	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0
003	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0
	АЖИЛЛАГСДЫН ТОО	46.00	46.00	-	100.0
	Удирдах ажилтан	3.00	3.00	-	100.0
	Гүйцэтгэх ажилтан	29.00	29.00	-	100.0
	Үйлчлэх ажилтан	14.00	14.00	-	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл	Зөрүү
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		<b>6,660,822.00</b>	(6,660,822.00)
21	Урсгал зардал		<b>6,660,822.00</b>	(6,660,822.00)
210	Бараа ажил үйлчилгээний зардал		6,660,822.00	(6,660,822.00)
2101	Цалин хөлс	-	5,920,731.00	(5,920,731.00)
210102	нэмэгдэл	-	5,920,731.00	(5,920,731.00)
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	740,091.00	(740,091.00)
210201	Тэтгэврийн даатгал	-	740,091.00	(740,091.00)
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		6,660,822.00	<b>(6,660,822.00)</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн тайлан		6,660,822.00	<b>(6,660,822.00)</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		6,660,822.00	<b>(6,660,822.00)</b>

### 3. Аудитын тайлан

#### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн /цаашид Шаамар сумын МСҮТ гэх/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн төлбөрийн цахим баримттай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “ЦЭСБ-АУДИТ” ХХК-ийн захирал аудитор Ч.Цэрэннадмид, ахлах аудитор Ш.Ганчимэг нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Шаамар сумын МСҮТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/09 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Шаамар сумын МСҮТ нь “Ур чадвартай мэргэжилтэн бэлтгэж, багш, ажилтан, суралцагчийн тасралтгүй хөгжлийг дэмжин ажиллана.” гэсэн зорилт тавин ажиллаж байна.

Шаамар сумын МСҮТ-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- Мэргэжил олгох, давтан сургалт зохион байгуулах,
- Хувиараа аж ахуй эрхлэгч иргэнийг аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх арга барил, ур чадвар эзэмшүүлэх сургалтад хамруулах,
- Үйлдвэрлэл дээр мэргэжлийн сургалт зохион байгуулах,

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар шинэчлэгдсэн,

- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дээд шатны төсвийн захирагч болох Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийгдээгүй байна.

### **3.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шаамар сумын МСҮТ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4. Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,383,517.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 13,835.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 буюу 9,684.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Шаамар сумын МСҮТ-ийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 166,611.8 мянган төгрөгөөр буюу 4.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1: Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	10.9	10.9
Хувь хүнээс авах авлага			
Татаас санхүүжилтийн авлага			
Байгууллагаас авах авлага		13,988.3	13,988.3
Урьдчилж төлсөн зардал			
Бараа материал	52,354.6	59,721.9	7,367.3
Үндсэн хөрөнгө	3,458,127.1	3,270,148.8	(187,978.3)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,510,481.7</b>	<b>3,343,869.9</b>	<b>(166,611.8)</b>
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,510,481.7	3,343,859.0	(166,611.8)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>3,510,481.7</b>	<b>3,343,869.9</b>	<b>(166,611.8)</b>

Авлага данс 13,988.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь 81.5 мянган төгрөгийн НДШ-ийн авлага, 13,906.8 мянган төгрөгийн түлш халаалтын авлагын үлдэгдлээс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 59,721.9 мянган төгрөг болж 7,367.3 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн хүнсний материал, аж ахуйн материал, хангамжийн материалын зарцуулагдаагүй үлдэгдлээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 4,337,142.2 мянган төгрөг болж өмнөх оноос 23,269.2 мянган төгрөгөөр өссөн нь ХНХЯ-аас 9,705.2 мянган төгрөгийн үнэ бүхий машин тоног төхөөрөмж /компьютер, олон үйлдэлт хувилагч машин/ үнэ төлбөргүй хүлээн авч, 13,564.0 мянган төгрөгийн жолооны тээврийн хэрэгслийн урсгал засварын материал худалдан авсан дүнгээр капиталжуулсантай холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 3,343,859.0 мянган төгрөг болж 166,611.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 1,189,912.2 мянган төгрөг болж өмнөх оноос 33,774.0 мянган төгрөгөөр буюу 2.9 хувиар өссөн байна. Энэ нь тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж болон, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгтэй холбоотой болно.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,356,523.9 мянган төгрөг болж өмнөх оноос 27,578.9 мянган төгрөгөөр буюу 0.9 хувиар буурсан байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Шаамар сумын МСҮТ нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг тус бүр 1,227,008.7 мянган төгрөгөөр тооцон төсөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 49,278.8 мянган төгрөгөөр бууруулж, **1,177,729.9 мянган төгрөгөөр баталсан байна.**

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,177,729.9 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,164,629.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, 7,500.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 5,600.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,164,629.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны орлого 7,216.2 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 2,150.0 мянган төгрөг нийт 1,173,996.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,168,981.1 мянган төгрөгийг зарцуулж, 5,004.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлж, **10,9 мянган төгрөгийн мөнгөний үлдэгдэлтэй байна.**

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **1,168,981.1** мянган төгрөг буюу 99.3 хувьтай тайлагнагдсан байгаа нь тогтмол зардал 4,415.4 мянган төгрөгөөр, цалин, НДШ-ийн зардал 3,336.5 мянган төгрөгөөр, томилолтын зардал 567.0 мянган төгрөгөөр, нормативт зардал 844.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 317.2 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 18,4 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд Шаамар сумын ЭМТ-өөс “Ковид-19 цар тахлын тусгаарлалтын тасаг”-ийн ажиллагсдын цалингийн зардлын санхүүжилт 6,660.8 мянган төгрөг төвлөрч, зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

**3.7.1** Үндсэн хөрөнгийн ангилалд ашиглаж байгаа боловч үлдэх өртөг нь “0” үлдэгдэлтэй болсон 267,924.9 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 74 нэр төрлийн хөрөнгүүдийг ашиглаж байгаа нь УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн 49 дэх “... дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээсээ материаллаа ялгаатай байвал цаашид дахин үнэлэх зайлшгүй шаардлагатай” гэсэн заалттай нийцэхгүй байна. Иймд “0” үлдэгдэлтэй хөрөнгийг цаашид ашиглах бол дахин үнэлэх эсвэл акталж устгах асуудлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

**3.7.2** Тайлант онд ХНХС-ын тушаалаар ур чадварын нэмэгдлийг шинэчлэн тогтоож өгөөгүйгээс тус МСҮТ-ийн захирал Б.Хишигжаргалд ХНХС-ын 2020 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/122 дугаар тушаалаар тогтоосон 25 хувиар тооцон 1,244.8 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг олгосон нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам” -тай нийцэхгүй байна. Цаашид төсвийн ерөнхийлөн захирагчийн зүгээс төсвийн шууд захирагчид олгох ур чадварын нэмэгдлийг тайлант онд шинэчлэн тогтоож байх шаардлагатай байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс 140 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 7 мэдээллийг хугацаа хоцроон, 2 мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэж байна гэж дүгнэлээ.

#### **3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт**

Шаамар сумын МСҮТ-ийн тайлант оны үйл ажиллагаанд 1,177,729.9 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 1,168,992.0 мянган төгрөгийг зарцуулан,

төсвийн төлөвлөгөөг 0.7 хувиар хэмнэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: *“.....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”* гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Шаамар сумын МСҮТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 1,493.3 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт, 2,445.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага, алдаа зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

3.11.1 Аудитын цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан 23,269.2 мянган төгрөгөөр шинээр нэмэгдэж, бүртгэгдсэн хөрөнгүүдийг биетээр тулган баталгаажуулах боломжгүй байсан учир дараагийн аудитаар анхааран үзэх нь зүйтэй юм.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 190,368.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 120,845.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг аудитын явцад залруулж, 896.2 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 68,627.6 төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өглөө.

### **4.1 Залруулсан алдаа**

- Тайлант онд түлш халаалтын зардлыг гэрээний үнийн дүнгээс 13,906.8 мянган төгрөгөөр илүү шилжүүлж, авлага үүсгэснийг 2022 оны 02 сарын төлбөрөөс нөхөн суутгуулж залрууллаа.
- Урьдчилгааг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлаар бүртгэсэн 93,374.3 мянган төгрөгийг залруулав.
- Жолооны сургалтын тээврийн хэрэгсэлд 13,564.0 мянган төгрөгийн бүрэн ээлж засвар хийсэн боловч уг хөрөнгийг капиталжуулаагүй, шууд зардалд бүртгэснийг залруулав.

### **4.2 Төлбөрийн акт**

1.Тушаал шийдвэргүйгээр захирал Б.Хишигжаргалд үр дүнгийн урамшуулал 896.2 мянган төгрөгийг олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”*, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 4.7 дахь *“Энэ журмын 4.3-т заасан нөхцөлийг хангасан багш, албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг тухайн сургалтын байгууллагын эрхлэгч, захирал гаргана. Сургалтын байгууллагын эрхлэгч, захиралд улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг томилсон эрх бүхий албан тушаалтан гаргана.”* гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд *“Нийцсэн бөгөөд зохистой байх”* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тушаал шийдвэргүйгээр олгосон улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

### **4.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

#### **1. Анхан шатны баримт хөтлөлт, бүрдүүлэлттэй холбоотой асуудал**

##### **1.1 Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд**

**1.1.1 Илрүүлэлт:** Тайлант онд 68,627.6 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

**1.1.2 Өгсөн зөвлөмж:** Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

#### **2. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал:**

**2.1 Илрүүлэлт:** Шилэн дансанд мэдээлбэл зохих 7 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг огт мэдээлээгүй байна.

**2.2 Өгсөн зөвлөмж:** Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4 гэсэн заалтуудыг зөрчсөн тул холбогдох мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Шаамар сумын МСҮТ	6	190,368.9	3	120,845.1	1	896.2			2	68,627.6